**ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БААТАРЖАВ ОВОГТОЙ ДЭЛГЭРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /Биелэлт/ | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлагад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг нэгтгэн боловсруулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | Хүргүүлсэн эсэх<br>Тийм-1, Үгүй-0 | Цахимаар-12 | 12 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 230 /дунджаар/ заалтын биелэлтийг сар бүр Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn сайтад цахимаар тайлагнаж байна. Биелэлтийн дундаж үзүүлэлт 89%-тай байна. | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |
| **Зорилт 2. Сайд болон Төрийн нарийн бичгийн дарга нарын хуралдааныг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтөлж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргана.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1 Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавина. | Зохион байгуулсан эсэх<br>Тийм-1, Үгүй-0 | 12 | 12 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 3 удаагийн шуурхай, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан нийт 15 удаа хуралдсан ба 15 удаагийн | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | (Хуралдааны тэмдэглэлийн тоо) | | | хуралдааны тэмдэглэл хөтөлж, шуурхагаас өгсөн 75 үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн танилцуулсан. | | |
| **Зорилт 3. Төрийн шагналын материалыг ЗГХЭГ-т уламжлах, Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналыг олгох болон байгууллагын ахмад настны судалгаа хийж, хүндэтгэлийн арга хэмжээг тус тус зохион байгуулна.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1 Байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмад настны нэгдсэн судалгаа гаргах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулна. | Судалгаа гаргасан эсэх<br>Тийм-1, Үгүй-0<br>Арга хэмжээний тоо | 1 | 1 | Сар шинийн баяр болон Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 27 ахмадад 2024 оны 02 дугар сарын 08-ны өдөр болон 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нийт 2 удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн. Уулзалтаар салбарын удирдлагууд өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийж бүтээсэн ажлуудаа танилцуулсан. ЦИХХХЯ цахим шилжилтийг эрчимжүүлж, хүн биш технологи засагладаг, авлигагүй нийгмийг бүтээх, иргэд төрийн үйлчилгээг хаанаас ч амар, хялбар, хурдан шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр болон сансар судлалыг хөгжүүлэхэд олон улсын түвшинд ажилласнаа танилцуулж, ахмадуудтайгаа зөвлөлдөж, тэдний санал бодлыг хүлээн авсан. | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 3.2 Ахмадуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, удирдлагад танилцуулах. | Шийдвэрлэсэн санал, хүсэлтийн тоо | - | 1 | Тайлант хугацаанд нийт 7 ахмадаас ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэх, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулж, албажуулсан. | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |
| 3. | Арга хэмжээ 3.3 Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | Арга хэмжээний тоо | 1 | - | Тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно. | 2024.01.02<br>2024.12.30 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 3.4 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нэгдсэн арга хэмжээ ICT-EXPO-г зохион байгуулах, арга хэмжээнд оролцох. | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно. | 2024.01.02 2024.12.30 | - |
| 5. | Арга хэмжээ 3.5 Салбарын спорт арга хэмжээнд оролцох. | Арга хэмжээний тоо | 2 | 1 | Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Засгийн газрын цом” спортын таван төрөлт тэмцээнд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 03-ны өдрүүдэд сагсан бөмбөг, гар бөмбөгийн төрөлд оролцсон. | 2024.01.02 2024.12.30 | 100 |
| **Зорилт 4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшил, ТББ-тай хамтран ажиллана.** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 4.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшил, ТББ-тай хамтран ажиллана. | Байгууллагын тоо | 0 | 1 | Тус яамнаас эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийн санал авах тухай 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/2668 дугаар албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлэн саналыг нэгтгэж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03/72 дугаар албан бичгээр төлөвлөгөөний төслийн саналыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 2024.01.02 2024.12.30 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.** | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 5.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан бичиг боловсруулах, шийдвэрлэх, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан | Албан бичиг хүргүүлсэн, шийдвэрлэсэн эсэх Архивт өгсөн эсэх Тийм-1, Үгүй-0 | | 2023 онд дээд газраас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 6 боть материалыг стандартын дагуу архивлан, архив, бичиг хэргийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. | 2024.01.02 2024.12.30 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | баримт бичгийг архивт хүлээлгэн өгнө. | | | | | |
| 2. | Арга хэмжээ 5.2. Албан чиг үүргийн дагуу удирдлагаас шилжүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | Хугацаанд нь шийдвэрлэсэн эсэх Тийм-1, Үгүй-0 | | Жилийн эцсийн байдлаар нийт 6 иргэн /өндөр настан/-ээс өргөдөл ирсэнийг хугацаанд нь шийдвэрлэсэн. | 2024.01.02 2024.12.30 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/109 дүгээр тушаалаар байгуулсан “Эцэг, эхийн зөвлөл”-ийн Нарийн бичгээр ажиллах | Арга хэмжээний тоо Тийм-1, Үгүй-0 | 1 | 1 | “Эцэг, эхийн зөвлөл”-өөс санаачлан ”Цахим орчинд гэр бүлээ хамгаалья” сэдэвт гэр бүлийн өдөрлөгийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж тус яамны албан хаагчид,эцэг, эх хүүхдүүдэд зориулан 3 төрлийн сургалт зохион байгуулсан. Арга хэмжээг. зохион байгуулахад 1 түрээсийн гэрээ, 3 сургагч багш хөлсөөр ажиллуулах гэрээг тус тус байгуулсан. Гэр бүлийн өдөрлөгийн хүрээнд “Зорилгоо тодорхйолгж, мэргэжлээ хэрхэн сонгох вэ” сургалтыг 14-18 насны хүүхэд, эцэг эхчүүдэд , “Цахим орчны эерэг ба сөрөг нөлөөлөл" сургалтыг 04-13 насны хүүхдүүдэд , "Хүүхдийн хөгжлийн онцлог, сэтгэцийн эрүүл мэнд" сургалтыг өсвөр насны хүүхдүүд, эцэг, эхчүүдэд мэргэжлийн сургагч багш нар тус тус хичээл зааж, зөвлөгөө өгсөн болно. Өдөрлөгт нийт 70 гаруй хүүхэд, 30 гаруй эцэг, эх оролцсон. | 2024.05.25 2024.05.25 | 100 |
| 2. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/22 дугаар | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, цахим аймаг | 2024.03.11 2024.03.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тушаалын хүрээнд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймагт албан томилолтоор ажиллах | Тийм-1, Үгүй-0 | | | бодлогын зөвлөмжийн хүрээнд цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх, төрийн цахим үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр “Цахимд хэвшье” /Digital first/ арга хэмжээг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, харьяа, салбар байгууллагууд, “Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын 16 компани хамтран 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрийн хооронд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймагт /Говийн бүсэд/ нийт төрийн байгууллагын удирдлага, албан хаагч 708, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид 92, багш, сурагч 857, экспо арга хэмжээнд 2000 иргэд хамруулан 5 танхимд сургалт, уулзалт зохион байгуулсан. | | |
| 3 | Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллах | | | | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/34, А/62, А/70 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулсан. | 2024.10.01<br>2024.12.30 | 100 |
| 4 | “Харилцаа холбооны түүхэн замналын музей”-н асуудал | | | | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эзэмшилд шилжүүлсэн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Монгол Улсын түүх, соёлын дурсгал “Анхны холбооны барилга”-ыг “Харилцаа холбооны түүхэн замналын музей”-н зориулалтаар ашиглах зорилготой арга хэмжээг авахад шаардлагатай хамтран ажиллах тухай 2024 | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 04/41 дүгээр албан бичгийг Гадаад харилцааны яаманд, 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 03/300 дугаар албан бичиг болон 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 03/958 дугаар албан бичгийг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд тус тус хүргүүлсэн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /Биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Хамтын ажиллагаатай олон улсын байгууллагаас зохион байгуулсан гадаад, дотоодын сургалтад хамрагдах. | Сургалтын тоо | 1 | 1 | АНУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн семинарт 2024 оны 9 дүгээр сарын 17-ний өдрөөс 9 дүгээр сарын 20-ны өдрүүдэд Эдийн засаг хөгжлийн яам дээр хамрагдсан.<br>БНХАУ-ын Худалдааны яамнаас Бээжин хотод зохион байгуулсан "Цахим худалдаа" сэдэвт семинарт 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд хамрагдсан. | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Удирдлагын академиас зохион байгуулдаг төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдах. | Сургалтын тоо | 1 | 1 | 1.Төрийн албаны зөвлөлөөс 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан 7:4:10 "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" сургалтад хамрагдсан.<br>2.Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан "Албан хэргийг монгол болон кирилл бичгээр хөтлөн | 2024.01.02<br>2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих, эрх зүй технологийн орчин бүрдүүлж, бэлтгэх хангах” зорилтын хүрээнд 4 жил тутам явуулдаг “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны явцын мэдээ, төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга сэдэвт 7:4:10 сургалтад хамрагдсан.<br>3.Төрийн албан хаагчийн Ёс зүйн хуулийн дагуу бүх шатны төрийн байгууллагын дэргэд Ёс зүйн дэд хороодын ажиллах журмыг танилцуулах 7:4:10 сургалтад хамрагдсан.<br>4.Авлигатай тэмцэх газраас “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” хүрээнд цахим сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 10:00-11:30 цагт зохион байгуулсан сургалтад хамрагдсан. | | |

**ТАЙЛАН БИЧСЭН:**

Тогтоол шийдвэрийн биелэлт, төр хувийн хэвшлийн түншлэл хариуцсан мэргэжилтэн — Б.Дэлгэрмаа / ......................... / — /2024.12.05/

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*